



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/175

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 5.1, "Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/21 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "ЖАЙКА" Олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулах "Амь тэнссэн үеийн түргэвчилсэн үнэлгээ, лавшруулсан тусламж" сэдэвт сургалтын удирдамж, сургалтад хамрагдах эмнэлгийн мэргэжилтний нэрсийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Очир/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтыг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Хүний нөөцийн бодлого зохицуулалтын алба /Т.Учрал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү, дотоод хяналтын алба /Т.Содгэрэл/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Д.ГАНЦЭЦЭГ

**“АМЬ ТЭНССЭН ҮЕИЙН ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ,
ЛАВШРУУЛСАН ТУСЛАМЖ”
СЭДЭВТ СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Үндэслэл:

Сүүлийн жилүүдэд Монгол улсын эрүүл мэндийн салбарын нөхцөл байдал сайжирсаар байгаа хэдий ч орон нутаг дахь эмнэлгийн тусламж үйлчилгээ харилцан адилгүй, өвчлөлийн бүтэц өөрчлөгдөж халдварт бус өвчин, осол гэмтэл өсөх болсон. Мөн эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын тогтолцоо нь боловсронгуй болоогүй гэх мэт асуудлууд тулгарч байна.

ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллага нь анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилго тавин эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлж эхэлсэн. Ялангуяа нэн түрүүнд сайжруулах шаардлагатай байгаа яаралтай тусламж болон холбогдох чиглэлүүдийг голчлон авч үзэхээс гадна, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах тал дээр түлхүү анхааран ажиллаж байна.

ЭМЯ, ЭМХТ, ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран яаралтай тусламжийн чиглэлээр зохион байгуулагддаг сургалтын талаар судалж, хэлэлцээний үр дүнд амь насанд аюултай эрсдэлд орсон өвчтөний биеийн байдалд үнэлгээ өгөх, амилуулах лавшруулсан тусламжийн арга техникийг эзэмшүүлэх (Advanced Assessment for life Support-AALS) сургалт зохион байгуулах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн. Үүнтэй холбогдуулан Япон улсад зохион байгуулагддаг AALS сургалтаас үлгэр жишээ аван сургалтын хөтөлбөр боловсруулж, нарийн ажилбар гүйцэтгэх боломжтой манекин ашиглан сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

Энэхүү сургалтын гол зорилго нь цаашид Монгол улсад AALS сургалт удирдах сургагч багшийг бэлтгэхэд оршино. Бэлтгэгдэн гарсан сургагч багш нь AALS сургалтыг зохион байгуулж, Монгол улсын яаралтай тусламж үйлчилгээний түвшинг дээшлүүлэх үйлсэд хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Сургалтын хөтөлбөр нь 1. Амилуулах лавшруулах тусламжийн сургалт, 2. Сургагч багш бэлтгэх сургалт гэсэн хэсгээгс бүрдэх ба дээрхи хоёр хэсгийг дүүргэсэн эмч сургагч багш болох юм.

Зорилго:

AALS сургалтын сургагч багш бэлтгэнэ. Бэлтгэгдэн гарсан сургагч багш нь цаашид AALS сургалт зохион байгуулж, (аймаг, нийслэлийн нэгдсэн эмнэлгийн эмч нарт чиглэсэн) эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж ажиллана.

Зорилт:

1. AALS сургалтын талаар ерөнхий арга техник эзэмших
2. AALS сургалтын сургагч багшид заах аргыг эзэмшүүлэх
3. Нарийн ажилбар гүйцэтгэх манекин ашиглах аргыг эзэмших
4. Сценари гүйцэтгэж үзүүлэх

Сургалтын хэлбэр: Богино хугацааны сургалт

Ажлын хэсгийн гишүүд: ЭМХТ-ийн ХНБЗА-ны мэргэжилтэн-1, ЖАЙКА-н төслийн ажилтан-1

Сургалтын хугацаа: 2018 оны 11 сарын 25-ны өдөр

Сургалт болох газар: ЭМХТ-ийн хурлын танхим

Эзэмших мэдлэг:

AALS сургалттай холбоотой нарийн тодорхой мэдлэг, AALS сургалтын төлөвлөгөө боловсруулах арга

Эзэмших чадвар:

AALS сургалтын сургагч багшийн заах арга зүй, нарийн ажилбар гүйцэтгэх манекин ашиглах арга, яаралтай тохиолдол бүхий сценари дээр ажиллаж үзүүлэх чадвар

Эзэмших хандлага:

Яаралтай тусламж шаардлагатай өвчтөнд зохих ёсны тусламж үйлчилгээ үзүүлж чадах эмч бэлтгэх чин сэтгэлтэй, ирээдүйн боловсон хүчин бэлтгэж Монгол улсын эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээнд хувь нэмэр оруулах хандлагыг төлөвшүүлнэ.

Сургалтын хэрэглэгдэхүүн:

Нарийн ажилбар гүйцэтгэх манекин 2 ширхэг, сэхээн амьдруулах яаралтай тусламжийн 2 иж бүрэн хэрэгсэл, FAST-н /түргэвчилсэн эхо/ хэв авиан хиймэл арьс /Sonoskin/ 1 ширхэг, ширээ 2, проектор, компьютер, дэлгэц.

Сургалтын арга зүй: Нэгдсэн лекц, дадлага, багийн ажиллагаа

Сургагч багш нар:

№	Овог нэр	Албан тушаал	Мэргэжил, боловсролын зэрэг	Ажилласан жил
1	Кимура Акио	Японы олон улсын эрүүл мэндийн судалгааны төвийн ЯТ-н төвийн захирал	Яаралтай тусламж, M.D	30-с дээш жил
2	Фүжита Сатоши	Асахикава анагаах ухааны их сургуулийн ЯТ-н тэнхимийн профессор	Яаралтай тусламж, M.D, Ph.D	30-с дээш жил
3	С.Алтансүх	УНТЭ, яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч	АУ-ны магистр	23
4	О.Янжив	УГТЭ, Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч	АУ-ны магистр	22
5	О.Чинбаяр	ХӨСҮТ, Яаралтай тусламжийн тасгийн эмч	АУ-ны магистр	15
6	Ө.Анхболд	СЭМҮТ, Яаралтай тусламжийн тасгийн эмч	АУ-ны магистр	20

Амь тэнссэн үеийн түргэвчилсэн үнэлгээ, лавшруулсан тусламж сэдэвт сургалтад хамрагдах эмч нарын нэрс /2018.11.25-ны өдөр/

№	Байгууллага	Оролцох эмч нар	Утас
1	УНТЭ-ийн ЯТ резидент эмч	Энхтөр Цэндсүрэн	99245012
2	Ховд аймгийн БОЭТ	Сандаг Баттуяа	99442799
3	Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэг	Боргилчулуун Алтантогос	99014349
4	УНТЭ	Шаравдорж Болор	99772949
5	Өвөрхангай аймгийн БОЭТ	Энхбаатар Бат-Ундрал	99042418
6	УНТЭ	Лувсандорж Алтантуяа	80980815
7	Чингэлтэй дүүрэг нэгдсэн эмнэлэг	Хүрэлбат Батцэцэг	91923848
8	УНТЭ-ийн ЯТ резидент эмч	Эрдэнэдалай Учрал	95096112

